

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2026 оны 05 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг хууль тогтоомж	Төсөв /сая.т өг/	Шалгуур үзүүлэлт тоо, хувь	Суурь түвшин 2025 он	Зорилтот түвшин 2026 он	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилго 1. Хүүхдэд сэргээн засах, уламжлалт тусламж, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, чанаржуулж мэргэшсэн багаар эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулан хүүхдийн амьдралын чанарыг нэмэгдүүлнэ.							
Зорилт 1. Хүүхдийн сэргээн засах төвөөр хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүдийн цар хүрээг нэмэгдүүлэн, уламжлалт сэргээн засах эмчилгээг хослуулан сэргээн засах эмчилгээг үзүүлнэ.							
1.1.1.	0-18 хүртэлх насны хүүхдүүдэд сэргээн засах тусламж үйлчилгээг тогтмол үзүүлэн тасралтгүй ажиллана.	1,632.2 УТ	Өдрийн эмчилгээнд эмчлэгдсэн хүүхдийн тоо.	103	115	2026 оны хагас жилийн байдлаар нийтдээ 2010 хүүхдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнээс : - Төвийн хэвтэн эмчлүүлэх тасагт /станционар/ 204 хүүхдийг хэвтүүлэн эмчилсэн байна. - Өдрийн сэргээн засах эмчилгээнд нийт 59 хүүхэд эмчлүүлсэн байна. 2025 оны хагас жилийн байдалтай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 7,3%-аар сайжирсан төдийгүй гүйцэтгэлийн хувь ханган 51,3%-тай ажиллаж байна.	50%
			Сэргээн засах төвийн орны эргэлт	34.3	35.0	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн статистик тоон мэдээллийг сар тутамд тайлагнан ажиллаж байна. Хүүхдийн сэргээн засах төвийн хэмжээнд: - Хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо – 204 - Ор хоног – 1428	50%

						• Орны фонд ашиглалт – 35.7 • Орны фонд ашиглалтын хувь – 115.2 • Дундаж ор хоног – 7.0 • Орны эргэлт – 5.1 байна. Өмнөх оны хагас жилийн байдалтай харьцуулбал фонд ашиглалт, орны эргэлт нэмэгдсэн байна.	
1.1.2.	Хөгжлийн бэрхшээлтэй болон хоцрогдолтой хүүхэдтэй ар гэр, асран хамгаалагч нарын хүүхдээ хөгжүүлэх, дэмжих, мэдлэг ур чадвар дадлыг үнэлэн, хүүхэд бүрийн онцлогт тохирсон хөдөлгөөний хөгжлийн үнэлгээ болон эцэг эхчүүдэд зориулсан гэрээр хийх дасгалын цахим гарын авлага, видео зөвлөмж бэлтгэж нэвтрүүлэх, сэргээн засах эмчилгээний төлөвлөгөөг гарган үр дүнг тооцон ажиллана.	-	Ар гэр, асран хамгаалагч нарын хүүхдээ хөгжүүлэх, дэмжих, мэдлэг ур чадвар дадлыг сорилын хамрагдалтын хувь	70%	75%	Хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хоцрогдолтой хүүхэдтэй ар гэр, асран хамгаалагч нарын хүүхдээ хөгжүүлэх, дэмжих, мэдлэг ур чадвар дадлыг хэвтэн эмчлүүлэх тасгаар хэвтэн эмчлүүлсэн 59 хүүхдэд үнэлэн, хүүхэд бүрийн онцлогт тохирсон хөдөлгөөний хөгжлийн үнэлгээ болох GMFM88 үнэлгээгээр үнэлэн эцэг эхчүүдэд зориулсан гэрээр хийх дасгалын гарын авлага тараан тус хүүхдүүдийн 31 хүүхэд давтан үзүүлэн үнэлгээг дахин үнэлэхэд хүүхдийн өөртөө үйлчлэх чадвар сайжирсан байна. Хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхийн 52,5%-д мэдлэг ур чадвар, дадлыг эзэмшүүлэн ажиллаж байна. 11 хүүхдийн эцэг эхэд зөвлөгөө өгсөн одоогоор ирэх хугацаа болоогүй төлөвлөсөн байна.	50%
		-	Эцэг эхчүүдэд зориулан бэлтгэсэн гэрээр хийх дасгалын видео зөвлөмжийн тоо	0	5	2026 оны хагас жилийн байдлаар тус хүүхдүүдэд зориулсан төвийн эмч сувилагч, хөдөлгөөн засалч нар хамтран бэлтгэсэн аутизмын тухай гарын авлага 1 ширхэг бэлтгэн хэвтэн эмчлүүлэгч нарт тараан ажиллаж байна. 2026 онд манай төвөөр онош батлагдсан аутизм оноштой 7 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн байна. Тус хүүхдүүд болон ар гэрийнхэнд гарын авлагыг танилцуулан ажилласан байна.	60%

						• Аутизмтай тохиолддог хүндрэлүүд • Харилцааны бэрхшээлүүд • Аутизмын давтагдмал зан үйл • Аутизмтай хүүхдийн хөдөлгөөний эв дүй зэргийг тайлбарласан мэдээллийг таниулан ажиллаа. Эрүүл үрс төв нь 2 төрлийн видео контентыг бэлтгэн өөрийн цахим хуудсаар нийтлэн ажиллаж байна. Үүнд: • Үений далайцын дасгал хэрхэн хийх • Тэргэнцэртэй хүүхдийг орноос хэрхэн зөв болгох талаар хийгдсэн байна.	
		-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг үнэлгээний хамрагдалтын хувь	100%	100%	Хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн шалгуур-GMFM88 үнэлгээний 5 үзүүлэлтийн үр дүнд: • Хэвтэх хөрвөх чадваргүй 21 хүүхдээс 42.8% нь сайжирсан байна. • Суух чадваргүй 18 хүүхдээс 55.5% нь сайжирсан байна. • Мөлхөх ба өвдөглөх чадваргүй 13 хүүхдээс 69.2% нь сайжирсан байна. • Зогсох чадваргүй 5 хүүхдээс 60.0% нь сайжирсан байна. • Явах чадваргүй 2 хүүхдээс 50.0% нь тус тус сайжирсан үнэлгээтэй байна. Давтан үзүүлж буй хүүхдүүдийн сайжралын дунд хувь 49,0%-тай байгаа нь эцэг эхэд гарын авлага зөвлөгөө мэдээлэл өгснөөр хүүхдийн сайжралын хувь	50%

						нэмэгдэх боломжтой харагдаж байна.	
		-	Хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхдийн онцлогт тохирсон хөгжлийн дэмжлэгийн богино болон урт хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан.	4	4	Сэргээн засах төвөөр хэвтэн эмчлүүлсэн нийт хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 27.8%-г эзэлж байгаа ба тус хүүхдүүдэд урт хугацааны сэргээн засах эмчилгээ, 22.6%-д нь уламжлалт эмчилгээтэй хавсарсан сэргээн засах эмчилгээ хийгдсэн ба 49.6%-д нь аливаа өвчний дараах богино хугацааны сэргээн засах эмчилгээ хийгдсэн байна.	50%
1.1.3.	Сэргээн засах төвд хэвтэн эмчлүүлсэн, өдрийн сэргээн засах эмчилгээнд хамрагдсан болон эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн 0-5 хүртэлх насны суурь өвчлөл бүхий хүүхдүүдийг хүлээн авч эмчилнэ.	-	Диспансерын хяналтыг нэмэгдүүлсэн бүртгэлийн тоо	19	20	Эрүүл үрс төвөөр хэвтэн эмчлүүлсэн 204 хүүхдийн 20,5% нь хоол тэжээлийн хөнгөн, дунд болон хүнд зэргийн тураалтай хүүхдүүд байна. Тус хүүхдүүдээс хүндэвтэр болон хүнд зэргийн тураал бүхий 11 хүүхдэд 2021 оны ЭМС-н А/379 тоот тушаалын дагуу эмчилгээний бэлэн хоол болон печень зэргийг өгч эмчилгээний явцад эмнэлзүйн шинж тэмдгийг хоолны дуршил, цусны сахар, гемоглобин хэмжээ, ухаан санааны байдал, хаван, амин үзүүлэлт, жингийн үзүүлэлт зэргийг тогтмол хянан зөвлөгөө өгч ажиллаж байна.	80%
			Урт хугацааны эмчилгээний эрүүлжилтийн хувь	-	50	Хоол тэжээлийн хүндэвтэр болон хүнд зэргийн тураалтай 11 хүүхдийг одоогоор эмчилж байна. Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төвд хянагдаж байгаа хүүхдүүдээс одоогийн байдлаар 5 хүүхэд давтан үзлэгтээ ирэн дараагийн ЭБХ болон печень идэж байна. Тус хүүхдүүдийн 14 хоногийн жингийн нэмэгдэл (үр дүн): • Дөлгөөн-Аялгуу: +900 гр • Хангал: +800 гр • Анар: +800 гр • Эрдэм: +700 гр	50%

						• Үжингоо: +300 гр нэмсэн үр дүн гарсан байна. Одоогоор хэвийн жинд хүрээгүй ч тодорхой жингийн нэмэгдэл гарч байгаа нь харагдаж байна.	
			Богино хугацааны эмчилгээний эрүүлжилтийн хувь	-	50	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүдийн 49.6%-д нь аливаа өвчний дараах богино хугацааны сэргээн засах эмчилгээ хийгдсэн байна. Тус хүүхдүүдийн биеийн байдал сайжран эмчилгээний үр дүн гарч зовуурь шаналгаа багасаж, амьдралын чанар сайжран үр дүн гарсан байна.	50%
			Эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	700	720	Эрүүл үрс төв нь 0-5 хүртэлх насны 989 хүүхдэд тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласнаас суурь өвчлөл бүхий болон жингийн дутагдалтай, цус багадалтай, сульдаа өвчлөл бүхий 422 хүүхэд үйлчлүүлснээс тус хүүхдүүдийг хүнд хөнгөний зэргээс хамааран эмчилгээ зөвлөгөө өгч ажилласан байна.	60%
1.1.4.	Сэргээн засах төвд шаардлагатай хөдөлмөр засал, сэтгэл засал эмчилгээг нэвтрүүлэн ажиллана.	3.000.0 БТ	Хөдөлмөр засалчийн тоо	-	1	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь MNS 6801:2019 стандартын дагуу хүний нөөцийг бүрдүүлэн ажиллахаар ажиллаж байна. Төвөөс 1 ажилтныг хөдөлмөр засалчаар суралцаж байна. 2026 оны 7-р сард ажиллахаар тохиролцон ажиллаж байна.	70%
			Сэтгэл зүйчийн тоо	-	1	Хүүхдийн сэргээн засах төвийн хэмжээнд сэтгэл зүйгээр мэргэшсэн хүүхдийн эмчтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна. Гэвч мэргэшсэн хүүхдийн сэтгэлзүй ч эмч одоогоор ярилцлагад орсон эмч байхгүй байна. Хүүхдийн сэтгэлзүйн онцлогийг ойлгодог, эмчилгээний чадамж бүхий мэргэжилтэн шаардлагатай хэвээр байна.	0%
			Эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	-	50	Эмчилгээнд хамрагдаагүй байна.	0%

1.2.	Зорилт 2. Шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалтын үйл ажиллагааг идэвхжүүлэн бэлэн байдлыг ханган ажиллана.						
1.2.1.	Зонхилон тохиолдох амьсгалын зам, гэдэсний бактери, зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулсан сургалтын тоо	4	6	2026 оны 02 сарын 04-ны өдөр Эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааны тухай ЭМС-ийн А/536, А/537, А/505 тоот тушаал, НХСЗ Эрүүл үрс төвийн даргын А/39 ХСХ-н багийн ажиллах журам А/40 Гар угаах халдваргүйжүүлэх заавар, А/41 Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах журам , А/42 Цэвэрлэгээ хийх журам, А/43 Шинэ ажилтныг дадлагажуулах журам, А/55 Сэргээн засах төвийн халдвар хяналтын багийг томилох тухай тоот тушаал, журмыг Эрүүл үрс төвийн бүх ажилчдад танилцуулах сургалт 1 удаа зохион байгуулан нийт 30 ажилтан хамрууллаа. Сургалтын үр дүнг сургалтын өмнөх болон дараах тестээр дүгнэхэд: • Сургалтын өмнөх тест дундаж хувь 85% • Сургалтын дараах тест дундаж хувь 94% болж сайжирсан үр дүнтэй ажиллалаа. Мөн нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл Үрс төв нь сургалтыг 2026 оны 02 сарын 06-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 12-р сургуулийн 5е ангийн 41 сурагчдад, мөн Нийслэлийн ерөнхий боловсролын 153-р сургуулийн 12а ангийн 47 сурагчдад нийт 2 сургуулийн, 2 бүлгийн, 88 сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгон ажилласан.Сургалтаар томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлааг дэмжих зөв дадал хэвшил, халуун аарц болон амин дэмийн хэрэглээний ач холбогдлын талаар мэдээлэл өгч хүүхдийн мэдлэгийг	50%

1.3.1.	Сэргээн засах төвд хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүдэд зургаар сэтгэцийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ хийж үнэлгээний түвшинг харгалзан сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэн шаардлагатай тохиолдолд дараагийн шатны тусламж үйлчилгээнд хамрагдахыг зөвлөж ажиллана.	500.0 БТ	Зургаар сэтгэцийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ хийсэн хүүхдийн хувь	15.2%	15.8%	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төвөөр хэвтэн эмчлүүлсэн хүүхдүүдээс төвийн хүүхдийн мэдрэлийн эмч болон хүүхдийн эмч нар хамтран хэт хөдөлгөөнтэй, тик илэрсэн, зан төрхийн хувьд өөрчлөлт ажиглагдсан болон орондоо шээсэн гэх өгүүлэмж бүхий 28 хүүхдээс буюу 13,7%-аас сэтгэл зүйн байдлыг тэдний зурсан зургаар дамжуулан хүүхдүүд өөрийн мэдрэмж, айдсыг тодорхойлохоор манай гэр бүл, миний айдаг зүйлс цуврал байдлаар зурахыг даалган зуруулан ажилласан. Энэхүү арга нь зөвхөн анхан шатны чиг баримжаа өгөх зорилготой бөгөөд тус чиглэлийн хүрээнд эцэг эхтэй хамтран зургийн чиглэлийг ярилцан зөвлөгөө өгч ажиллаа.	80%
			Дараагийн шатлалд илгээсэн хүүхдийн тоо	8	Тухай бүр	Төвийн эмч нар тус 28 хүүхдийн сэтгэлзүйн байдлыг зургуудыг харж хоорондоо ярилцан дүгнэхэд тик илэрсэн, шээс задгайрсан, зан төрхийн хувьд өөрчлөлт бүхий хүүхдүүд өөртөө итгэлгүй, ямар нэгэн айдастай, дотроо уур бухимдал хуримтлагдсан, ялангуяа хайр халамжаар дутагдсан ганцаардсан байдлууд их ажиглагдлаа. Төвийн хэмжээнд тус хүүхдүүдийг дараагийн шатлалд гэхээсээ илүү эцэг эхтэй ганцаарчилсан ярилцлага өрнүүлэн дараа дахин хэвтэхийг санал болгон зөвлөгөө өгч ажилласан байна.	50%
1.3.2.	Сэргээн засах тусламж үйлчилгээнд хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн шалгуур GMFM 88 үнэлгээг ашиглан хүүхэд бүрд тохирсон сэргээн засах төлөвлөгөөг боловсруулж, эмчилгээний үр дүнг 10-	-	GMFM үнэлгээнд хамрагдсан хүүхдийн хувь	70%	75%	Хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн шалгуур- GMFM88 үнэлгээг өөрийн байгууллагат нэвтрүүлэн 2026 оны хагас жилийн байдлаар сэргээн засах төвийн амбулаторийн хэсгээр үйлчлүүлсэн 502 үйлчлүүлэгчээс хөдөлгөөний хоцрогдолтой, сульдаа өвчний дараах булчингийн сулралтай, тархины саатай, хөгжлийн үе шат шалтгаангүй удааширсан	100%

	аас дээш хувиар ахиулах.					72 хүүхдүүдээс 59 хүүхдэд буюу үнэлэх шаардлагатай хүүхдүүдийн 82%-д GMFM-88 үнэлгээгээр үнэлэн хөдөлгөөн засал болон уламжлалт сэргээн засахын эмчилгээ хавсран хийгдэж байна.	
			Эмчилгээний үр дүн 10%-аас дээш гарсан хүүхдийн тоо	-	20	Хүүхдийн сэргээн засах төвд хүүхдэд сэргээн засах эмчилгээ хийгдсэнээр урт хугацаанд хүүхдийн амьдралын чанар дээшлэх болон өөртөө үйлчлэх чадвар бага хэмжээгээр нэмэгддэг учир эмчилгээний үр дүн 1-2 сард тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Гэвч тус 59 хүүхдүүдийн: - Хэвтэх хөрвөх чадваргүй 21 хүүхдийн 14 эргэж хөрвөөсөн - Суух чадваргүй 18 хүүхдийн 9 суудаг болсон - Мөлхөх өвдөглөх чадваргүй 13 хүүхдийн 5 чаддаг болсон - Зогсох чадваргүй 5 хүүхдийн 2 богино хугацаанд зогсдог болсон - Алхах чадваргүй 2 хүүхдийн 1 нь алхдаг болсон - Хурдан, унахгүй алхаж гүйхдээ унадаг 15 хүүхдийн 9 нь булчингийн хүч хүчдэл сайжирсан үр дүн гарсан байна.	100%
1.3.3.	Сэргээн засах төвд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэн ажиллана.	4.600.0 БТ	Тоног төхөөрөмжийн тоо	91	95	Сэргээн засах төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 6801:2019 стандартад заасан тусламж, үйлчилгээнд тохирсон дараах тоног төхөөрөмж байхаар: • Хөдөлгөөн заслын тоног төхөөрөмж • Алхах дасгал хийх тоног төхөөрөмж • Мэдрэлийн эмгэгтэй хүнд ашиглах үйл ажиллагааны цочруул • Физик эмчилгээний тоног төхөөрөмж • Аэробик, бие бялдаржуулалт дасгалын төхөөрөмж • Өдөр тутмын үйл ажиллагааны	100%

						чадвар сайжруулах дасгалын тоног төхөөрөмж Харилцах чадварыг сайжруулах тоног хэрэгсэл бүхий нийт 95 тоо ширхэг бүхий тоног төхөөрөмжүүд төрийн худалдан авах үйл ажиллагааны газартай хамтран тоног төхөөрөмжүүдийг бүрдүүлэн ажилласан.	
			Хөдөлгөөн заслын тоног төхөөрөмжийн тоо	10	12	Үүнээс хөдөлгөөн засал болон физик эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан ажиллахаар зорин ажиллаж байна. 2026 оны хагас жилийн байдлаар: ➤ Хөдөлгөөн заслын өрөөний тоног төхөөрөмжийн хангалт – 88,2% ➤ Физик эмчилгээний хэсгийн тоног төхөөрөмжийн хангалт – 87,5% тус тус болгон нэмэгдүүлэн ажиллаж байна. Цаашлаад бусад тоног төхөөрөмжийн хангалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэн ажиллахаар байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Одоогоор хөдөлгөөн заслын тоног төхөөрөмж 16 болсон байна.	100%
			Физик эмчилгээний хэсгийн тоног төхөөрөмжийн тоо	18	20	Сэргээн засах төвийн бүтэц үйл ажиллагааны стандартын дагуу сэргээн засах төвийн физик эмчилгээний тоног төхөөрөмж тоо 19-д хүргэн ажиллаж байна.	50%
1.3.4.	Сэргээн засах төвөөр хэвтэн эмчлүүлж байгаа хэл заслын тусламж үйлчилгээ шаардлагатай хүүхдүүдэд тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.	-	Хэл засалчийн тоо	-	1	Эрүүл үрс төвийн 1 ажилтныг хэл заслын сургалтад хамруулан ажилласан. Тус ажилтан 2026 оны 06 сарын сүүлээр төгссөнөөр тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх боломжтой байна.	100%
			Хэл ярианы хоцрогдолтой хүүхдийн тоо/эмчилгээний үр дүн тооцсон хувь	38/-	50/30%	Одоогоор тусламж үйлчилгээ үзүүлээгүй байна.	

1.3.5.	Хэвтэн эмчлүүлэгчдэд хавтгай тавхайг илрүүлэх оношилгооны орчин үеийн аргыг нэвтрүүлэн, тогтмолжуулна.	1.200.0 УТ	Илрүүлэг үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо	20	20-30	Хүүхдийн хавтгай тавхайг эрт үед нь оношлох нь маш давуу талтай ба цэцэрлэгийн 4-6 нас хүртэл хүүхдийн тавхайн нум бүрэн хэлбэржиж дуусаагүй, мөгөөрслөг хэвээр байдаг тул энэ үед засах, урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой. Хүүхдийн тулгуур эрхтний эмгэгийг эрт илрүүлэх зорилгоор зохион байгуулсан "Хавтгай тавхай илрүүлэх үзлэг"-т СХД болон ЧД-н цэцэрлэгийн ахлах болон бэлтгэл ангийн нийт 904 хүүхдийг илрүүлэг үзлэгт хамруулан ажилласан байна. Үүнээс хавтгай тавхайн өөрчлөлт илэрсэн 392 хүүхэд буюу / 43.4 % /, хэвийн нь 512 хүүхэд буюу 56,6% байна.	100%
			Түүнээс хавтгай тавхайтай хүүхдийн эмчилгээний хамрагдалтын хувь	90%	90-95%	Хавтгай тавхай өөрчлөлттэй 392 хүүхдийн багш нарт, эцэг эхчүүдэд зөвлөгөө өгч ажиллалаа. Цэцэрлэгийн насны хүүхдийн тавхайн булчин, шөрмөсийг чангалах замаар нум үүсгэх дараах зөвлөмжийг зөвлөлөө. Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв нь тус хүүхдүүдэд цэцэрлэгийн эмч нараар дамжуулан зөвлөгөө тараах материалыг бэлтгэн тарааж хавтгай тавхай бүхий хүүхдэд шаардлагатай дасгал хөдөлгөөн, амьдралын хэв маягт нөлөөлөх зөвлөгөө өгч ажиллаа. Мөн хавтгай тавхай өөрчлөлттэй 392 хүүхдийн 19% нь тус эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 21% нь хөдөлгөөн засалчаас зөвлөгөө мэдээлэл дасгал хөдөлгөөн заалгасан.	40%
1.4.	Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулна.						
1.4.1.	“Сайн туршлага - 2025” арга хэмжээний шилдэг	1.200.0	Хэвшүүлсэн бүтээлийн тоо	2	2	2026 оны байдлаар заавал хэвтүүлэх бүтээлийн жагсаалтаас ижил төстэй	50%

	бүтээлийг өөрийн байгууллагад нутагшуулан ажиллана.	БТ				байгууллага болох “Бяцхан тэмүүлэл ХСЗТ”-н хавтгай тавхай оношилгоонд foot mirror толин хайрцаг нэвтрүүлсэн сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллаж байна. Эрт илрүүлгийн ажилд уг туршлагын ашиглан 904 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	
			Сайн туршлага түгээн дэлгэрүүлэх сургалтад хамрагдсан ажилчдын тоо	30	40	Сэргээн засах төв нь 2025 оны “Сайн туршлага” арга хэмжээнд 2 бүтээлээр сайн туршлага номд орсон боловч танилцуулах арга хэмжээ болон сургалтууд зохион байгуулагдаагүй учир одоогоор сургалтад хамрагдаагүй байна.	50%
1.4.2.	Эрүүл мэндийн мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багийг орон тоогоор тогтвортой ажиллуулна.	-	Үндсэн орон тооны гишүүний тоо	-	1	Чанарын багийн ахлагч: Л. Эрдэнэбулаг 2022 оноос ЭМТҮЧАБ-н багийн ахлагчаар ажилласан. Хавсран гүйцэтгэдэг Чанарын менежер: Б. Үүрийнцолмон 2025 оноос ажиллаж байна. Уламжлалтын их эмч Орон тооны ажилтан Эрсдэлийн менежер, мэдээллийн ажилтан: Д. Түмэн-Өлзий 2023 оноос ЭМТҮЧАБ-н багийн гишүүнээр ажиллаж байна. Эрүүл үрс төвийн чанарын багийн ажилчид дунджаар 24-36 сарын хугацаанд орон тооны бус гишүүнээр ажиллаж байна.	100%
			Орон тооны бус гишүүний тоо	3	2	ЭМТҮЧАБ-ын баг нь 2026 онд орон тооны бус гишүүдтэй үйл ажиллагаа явагдаж байна. 2023 онд чанарын багийн ахлагч, чанарын менежер, чанарын мэдээллийн ажилтантай байсан бол 2025 оноос чанар менежер болон аюулгүй байдал эрсдэл хариуцсан ажилтныг тус тусад нь их эмч томилон 2019 оны 166/565 тушаалыг үндэслэн томилон тусламж үйлчилгээг	100%

						үзүүлж байна. 2025 оны 12 сарын 25-ны өдрийн төвийн даргын А/37 тоот тушаалын дагуу чанарын багийн дарга, чанарын менежер болон аюулгүй байдал, эрсдэлийн менежер гэсэн орон тооны 1, орон тооны бус 2 гишүүдтэй ажиллаж байна.	
1.4.3.	Байгууллагын чанарын өвөрмөц үзүүлэлтийг боловсруулах	-	Чанарын үндсэн үзүүлэлтийн дундаж хувь	85%	88%	Тусламж үйлчилгээний чанарын өвөрмөц үзүүлэлт, чанарын шалгуур үзүүлэлтийн үнэлгээний аргачлалыг төвийн даргын тушаалаар боловсронгуй болгож сэргээн засах төвийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 6 чиглэл, 30 үзүүлэлтээр гарган, түүнийг үнэлэх аргачлалыг боловсруулан баталгаажуулан ажиллаж байна. Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төвийн чанарын шалгуур үзүүлэлтийн үнэлэн дундаж үзүүлэлтээс буурсан үзүүлэлт байхгүй, чанарын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ хагас жилийн байдлаар 87,6% -тай байна.	85%
1.4.4.	СХД-н эмнэлэг болон өрхийн эрүүл мэндийн төвүүд, ТББ-тай хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллана.	-	Хамтран ажилласан байгууллагын тоо	-	3	2026 оны хагас жилийн байдлаар нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төв нь СХД болон ЧД-н цэцэрлэгүүд, СХД-н ӨЭМТ, СХД-т байрлах “Нархан” ТББ болон СХДНЭ зэрэг байгууллагатай хамтран үйл ажиллагаа явуулж байна.	100%
			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	Дараах байгууллагуудтай дараах үйл ажиллагааг хамтран ажиллаж байна. - СХД болон ЧД-н 18 цэцэрлэгтэй хамтран эрт илрүүлгийн ажлыг зохион байгуулан ажилласан - СХД-н “Наран манал” ӨЭМТ-тэй хамтран ажилчдын түргэвчилсэн шинжилгээнүүдийг өгөх болон томуугийн вакцинжуулалтын ажлыг зохион байгуулан ажилласан. - СХД-т байрлах “Нархан” төрийн бус байгууллагатай хамтран эцэг	100%

						эх байхгүй, эцэг эх нь үл хайхран хүчирхийлэлд өртсөн болон асран халамжлах орон гэргүй болсон хүүхдүүдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагатай хамтран хагас жилийн байдлаар 35 хүүхдийг хэвтэн эмчлүүлээд байна. СХДНЭ-тэй хамтын ажиллагааны хүрээнд ажилчдын шинжилгээ болон шаардлагатай тохиолдолд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.	
1.4.5.	MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага гадаад болон дотоод орчны шаардлагыг хэрэгжүүлэн ажиллана.	-	Гадаад орчны шаардлагын хэрэгжилтийн хувь	86.4%	87.0%	Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв нь эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS7014:2023 стандартын дагуу өөрийн байгууллагын хэмжээнд шалгуур үзүүлэлтийг боловсруулан ашиглаж байна. Тус үнэлгээг чанарын баг зохион байгуулан үнэлэн ажиллаа. 2026 оны хагас жилийн байдлаар гадаад орчны үнэлгээ 85%-тай байна. - Эмнэлгийн байгууллагын яаралтай тусламжийн автомашины зогсоол тэмдэглээтэй, чөлөөтэй, орц гарц нээлттэй зохион байгуулах талд дээр сэргээн засах төвийн 80 ор бүхий эмнэлгийн барилга ашиглалтад орсноор гадаа зогсоолын тэмдэг тэмдэглэгээний ажил бүрэн дуусаагүй байгаа учир байхгүй үнэлсэн байна. - Байгууллагын нүүрэн талд, нийтэд харагдахуйц орох гарах хаалганы орчимд байрлуулсан барилга улсын комисс хүлээн аваагүй учир бүрэн хангаагүй гэж үнэлсэн байна. Байгууллагын шинэ барилга ашиглалтад орсноор дараах зүйлсийг бүрдүүлэх боломжтой харагдаж байгаа учир дараах	70%

						байдлаар үнэлсэн байна. Мөн НЭМГ-н байцаагч нар тус стандартын дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн манай байгууллагад ажилласан.	
			Дотоод орчны шаардлага хэрэгжилтийн хувь	86.8%	87.0%	Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв нь эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS7014:2023 стандартын дагуу өөрийн байгууллагын хэмжээнд шалгуур үзүүлэлтийг боловсруулан ашиглаж байна. Тус үнэлгээг чанарын баг зохион байгуулан үнэлэн 2026 оны хагас жилийн байдлаар дотоод орчны үнэлгээ 84,2%-тай байна. Дотоод орчны үнэлгээгээр дараах үйл ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна. Үүнд: – Хүлээгийн өрөөг тохижуулах тал дээр одоогоор төвийн үйл ажиллагаа явагдаж буй барилгад өөрийн нөөц боломжид тулгуурлан хүүхэд хүлээн авах хэсэгт хүлээлгийн хэсгийг зохион байгуулсан байна. Тус хэсгийн ханыг цайвар суурьтай, эмнэлгийн зориулалттай будгаар будсан, агаарын солилцоо хийх боломжтой, гэрэлтүүлэг сайтайгаар зохион байгуулсан байна. – Үйлчлүүлэгчид нээлттэй мэдээлэл хүргэхээр зурагт байрлуулан мэдээ мэдээллийг түгээн ажиллаж байна. – Хүүхдийн тусламж үйлчилгээ үзүүлэх усан эмчилгээний өрөө, бариа эмчилгээний хэсэгт анхаарал татахуйц зураг, дүрслэл, эрүүл ахуйн шаардлага хангасан хэд хэдэн тооны тоглоомуудыг байршуулан ажиллаж	70%

						байна.	
1.4.6.	Эмчилгээ, үйлчилгээнд гарсан тохиолдолд (алдаа зөрчилд) анализ хийж цахим тохиолдлын санд бүртгэн, зөвлөмж өгөх, зөвлөмжийн гүйцэтгэлийн хяналтыг сайжруулна.	-	Цахим тохиолдлын санд бүртгэгдсэн эмнэлзүйн тохиолдлын тоо	1	1	Цахим тохиолдлын санд бүртгэлтэй болохоор G-mail хаягаар бүртгэлийг хүсэлт өгсөн боловч одоогоор шийдвэрлэгдээгүй байна. Байгууллагын хэмжээнд одоогоор ноцтой тохиолдол бүртгэгдээгүй учир цахим тохиолдлын санд бүртгэл үүсгээгүй байна.	100%
			Тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг сургалтын тоо	4	4	2026 оны хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд 2 удаагийн хэлэлцүүлгийн зохион байгуулан ажилласан байна.	50%
			Адил агуулгатай таагүй, ноцтой болон эмнэлгийн алдааны тоо	0	0	Төвийн хэмжээнд хагас жилийн байдлаар адил агуулга бүхий таагүй тохиолдол бүртгэгдээгүй байна. Мөн ноцтой болон эмнэлгийн алдаа бүртгэгдээгүй байна. Цаашид тохиолдол бүрийг алдалгүй бүртгэн мэдээлэн ажиллахад анхааран ажиллаж байна.	70%
1.4.7.	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тогтмол байгууллагын бүх сувгаар хүлээн авч, хариуг албан ёсоор өгч шийдвэрлэн үйлчлүүлэгчид ээлтэй орчныг бүрдүүлэн ажиллана.	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хоног	3	3	Эрүүл үрс төвийн хэмжээнд өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх төлөвлөгөөг 2026.01.16-ны өдрөөр төвийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Иргэдийн гомдол, саналыг хүлээн авах, тайлагнах тухай” 154 тоот тушаалын дагуу сэргээн засах төвийн хэмжээнд ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэдэг. НХСЗ-Эрүүл үрс төвийн хэмжээнд ирсэн үйлчлүүлэгчдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархлыг төвийн албаны утас болох 77082651 дугаарын утсаар, сэтгэл ханамжийн судалгаагаар, чанарын менежер өөрийн	100%

						биеэр болон 86060100 утсаар, санал, хүсэлтийн хайрцаг, сувиллын веб хуудсаар хүлээн авч байна. 2026 оны хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдолгүй ажиллаж байна.	
			Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	100%	100%	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төв нь ажилчдын цаг ашиглалтыг ERP системээр тогтмол хянан ажилладаг бөгөөд 2026 оны 01 сараас хойш эмч, ажилтнуудын хувьд биеэр, ERP системээр, 1111 төвөөр өргөдөл, гомдол ЭМТҮЧАБ болон хүний нөөцийн албанд ирээгүй ажиллаж байна.	100%
1.4.8.	Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Төсвийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулахгүй өр , авлага үүсгэхгүй ажиллаж байна. эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гарган, дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр ханган ажиллаж байна.	50%
1.4.9.	Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, төрийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, тайлагнах	-	Байгууллагын эд хөрөнгийг хагас бүтэн жилээр явуулж, эд хөрөнгө картын дагуу бүртгэл хөтлөх	100%	100%	2026 оны хагас жилийн байдлаар төвийн даргын А/14 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдон тооллогын комисс ажиллаж байна. Одоогоор тооллого бүрэн дууссан тайлан нэгтгэлийн ажил явагдаж байна. 6-р сарын 2 дахь 7 хоногт багтан тайлагнахаар ажиллаж байна. Тооллогын комиссын багийн бүрэлдэхүүнээр төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Төрийн өмчийн орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай” цахим сургалтад багийн гишүүд бүгд хамрагдан ажиллаж байна.	70%

						Цаашид төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны статистикийн маягт, түүний нөхөх заавар”, “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягт, түүний нөхөх заавар”, мөн 2026 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах журам”-ын дагуу нэгдсэн цахим системээр тооллогын ажлыг зохион байгуулж байгаатай холбогдуулан бэлтгэн ажиллаж байна.	
1.4.10.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж санхүүгийн мэдээ, мэдээллийг цаг тухай бүрд бэлтгэн мэдээлэх	-	Шилэн дансны хэрэгжилтийн хувь	100%	100%	Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас хагас жилийн байдлаар 67 мэдээлэл байршуулсан байна. Үүнээс: – Хугацаа хоцорсон мэдээлэл- 2 – Мэдээлээгүй мэдээлэл байхгүй болно,	48%
1.4.11.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	2	2	2026 оны худалдан ажиллагааны төлөвлөгөө гарган баталгаажуулан шилэн дансанд байршуулсан байна Байгууллагад авсан эд хөрөнгийн зохих журмын дагуу дансанд бүртгэж, мөн эд хариуцагчийн картад нэмж бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллаж байна.	50%
1.4.12.	Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж байгууллагын нэг ажилтныг бэлдэж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэн ажиллана.	-	Шинээр нэмэгдсэн авлагагүй донорын тоо	1	2	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн хэмжээнд донортой болохоор ажилчдын эрт илрүүлэгт хамруулан эрүүлжүүлэн ажилласан. 2026 оны хагас жилийн байдлаар 2 ажилтан цус төвд очин 1 удаа 2 литр цус хандивлан ажилласан байна.	100%

1.5.	Зорилт 5. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн зорилтын хүрээнд Албан хаагчдыг сургалтаар мэргэшүүлэн хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэн ажиллах						
1.5.1.	Хүний нөөцийн хэрэгцээний төлөвлөлтийг үндэслэн ажлын байранд сэлгэн ажиллуулахтай холбоотой мэдлэг чадварыг эзэмшүүлэхэд дагалдуулан суралцуулна.	-	Сэлгэн ажилласан ажилчдын тоо	6	6	Тус сэргээн засах төвийн ажлын ачааллыг тэнцүүлэх, хэд хэдэн ажлын байранд ажиллах чадвар эзэмшүүлэх, нэг ажлын байран дээр удаан ажилласнаас үүсэж болох гаднын нөлөөнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 6 албан хаагчийг мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дагалдуулан ажлын байрны дадлага хийлгэн сэлгэн ажиллуулсан.	100%
1.5.2.	Эмч, эмнэлгийн ажилчдын сургалтыг хэрэгцээнд суурилж тогтмол тасралтгүй сургалт зохион байгуулан ажлын байран дээрх сургалтыг нэмэгдүүлэн ажиллана.	600.0 БТ	Ажлын байранд зохион байгуулагдаж буй сургалтын тоо	150	48	Эрүүл Үрс төв нь дотооддоо төвийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг сайжруулах зорилгоор 2026 оны сургалтын төлөвлөгөөндөө 48 сургалт төлөвлөсөн бөгөөд үүнээс 21 сургалтыг төвийн хэмжээнд зохион байгуулж, сургалтын төлөвлөгөөний биелэлт 44%-тай явагдаж эмчилгээний тасгийн тусламж үйл ажиллагаатай сургалтад тасгийн ажилчдын хамрагдалт 78%-тай явагдаж байна.Энэ нь эмчилгээний тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өдөр, шөнийн ээлж болон 24 цагийн жижүүрт үүрэг гүйцэтгэдэгтэй холбоотой юм. Тухайлбал, ээлжээс буусан болон амралтын цаг таарсан ажилтнууд сургалтад биеэр оролцох боломжгүй байсан нь ирцийн хувьд нөлөөлсөн болно. Цаашид ээлжийн ажилтай албан хаагчдыг нөхөн сургах, цахимаар сургалтын материалыг хүргүүлэх хэлбэрээр хамрагдалтыг 90%-д хүргэхээр зорилт тавин ажиллаж байна.Нийт ажилчдыг хамруулсан сургалтад ажилчдын 80% хамрагдан ажиллаж байна.	87.5%

1.5.3.	Байгууллагын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа болон 1313.mn платформын хэрэглэгчийн үнэлгээг тогтмолжуулан, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулна.	-	Албан хаагчдын сэтгэл ханамжийн хувь	98.5%	99.0%	ЭМС-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны А/578 дугаар тоот тушаалын дагуу сэргээн засах төвийн нийт 33 ажилтнаас сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллаан ажилчдын ерөнхий сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хувиар тооцвол эерэг сэтгэл ханамжийн хувь-98,6%-тай байна.	50%
			Хэрэглэгчийн үнэлгээний оноо	4.6	4.8	2025 оноос эхлэн сэтгэл ханамжийн судалгааны түүврийн хэмжээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ны А/346 тоот тушаалын дагуу статистикийн үндсэн зарчим болон байгууллагын үйлчлүүлэгчдийн бодит тоон мэдээлэлд тулгуурлан тооцоолол хийн итгэлцлийн түвшнийг 95%, алдааны хязгаарыг 5% байхаар төлөвлөн сард 20 үйлчлүүлэгчээс судалгаа аван ажиллаж байна. Хэрэглэгчийн үнэлгээний оноо руу шилжүүлбэл үнэлгээний оноо 4.75 байна.	75%
			Түүний мөрөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	2	Тухай бүр	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа : ➤ Байгууллагын удирдлагын зүгээс ажилтнуудынхаа эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хувийн хамгаалах хэрэгсэл (амны хаалт)-ийг нэгдсэн зохион байгуулалттайгаар тарааж, дэмжлэг үзүүлэн ажиллалаа. ➤ Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэлхийн өдөртэй холбогдуулан хорт хавдрын талаарх зөвлөмж, хавдраас урьдчилан сэргийлэх талаар сургалтыг 2026 оны 03 сарын 06 өдөр “Эрүүл үрс төв”-ийн уламжлалтын их эмч Б.Лхамдулам, Ахлах сувилагч Д.Даваадулам, сувилагч М.Нямцэрэн, туслах сувилагч Х.Мөнхшүр нар хамтран зохион байгуулан ажилласан. Хүний нөөцийн хөгжих боломж: ➤ Эрүүл үрс төвийн хүүхдийн эмч	100%

1.6.1.	Төрийн албан хаагчдын харилцаа хандлагыг дээшлүүлэх замаар ёс зүйн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулан арга хэмжээ зохион байгуулан ажиллана.	1.000.0 БТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	Нийслэлийн сэргээн засах Эрүүл үрс төв нь олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2026 оны 03 сарын 06-ны өдөр Ёс зүйн багаас нийт эмэгтэй ажилтнуудад урам зориг өгөх, талархлын үгтэй захидал өгч, баяр хүргэлээ. Энэ нь ажилчдын хоорондын хүндэтгэл, эерэг уур амьсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа боллоо. Түүнчлэн энэхүү үйл ажиллагаа нь ажилтнуудын харилцан хүндэтгэл, байгууллагын эерэг соёлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн болно. "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалтыг 2026 оны 05 сарын 04-ны өдөр амбулаторийн өрөөнд зохион байгуулж, нийт 19 эмч, сувилагч, туслах ажилтнууд хамрагдлаа. Сургалтын явцад дараах агуулгыг танилцуулав. Үүнд: • Эрүүл мэндийн салбарын ёс зүйн үндсэн зарчим • Ажилтны мэргэжлийн хариуцлага • Өвчтөнтэй харилцах зөв хандлага • Багийн хамтын ажиллагаа ба ёс зүй Ажлын байран дээр ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үнэ цэнэ" сургалтад хамрагдсан. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор уг сургалтыг ажлын байран дээр зохион байгууллаа. Сургалтын хүрээнд "Урмын үгээр самбараа дүүргэе" урианы дор эерэг хандлага төлөвшүүлэх нэмэлт үйл ажиллагааг зохион байгууллаа. Ажилтнууд хоорондоо нэг нэгэндээ зориулан урмын үг, талархлын үгс бичиж, самбарт байршуулсан. Үүнд:	100%
--------	---	------------	--------------------------------------	---	---	---	------

						- Хамт олныхоо хөдөлмөрийг үнэлсэн талархлын үгс - Өдөр тутмын ажлыг урамшуулсан сэтгэлийн үгс - Багийн уур амьсгалыг дэмжсэн уриалга, урам зоригийн өгүүлбэрүүд Энэхүү үйл ажиллагаа нь ажилчдын хоорондын харилцааг ойртуулж, эерэг уур амьсгал бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлээ. Сэргээн засах төвийн амбулаторийн хэсэгт эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, харилцан хүндэтгэлтэй харилцааг төлөвшүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн байгууллагын ажилтны ёс зүйн хэм хэмжээ” болон “Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйн хэм хэмжээ”-г мэдээллийн самбарт байршуулан сурталчилж, таниулан ажилласан. Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан Нийслэлийн ерөнхий боловсролын сургуультай хамтран зохион байгуулсан мэргэжил сурталчлах өдөрлөгийн хүрээнд “Инээмсэглэл – аз жаргалын даавар ялгаруулдаг” уриа дор оролцогчдод зориулсан гэрэл зураг авах буланг бэлтгэн ажилласан. Сэргээн засахаар хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдийн асран хамгаалагч нарт “Хүүхдийн эмчилгээнд эцэг эх, асран хамгаалагчийн ёс зүйтэй оролцоо” сэдэвт сургалтад 14 эцэг эх саран хамгаалагчийг хамруулсан	
			Ёс зүйтэй холбоотой зохион байгуулсан сургалтын тоо	2	2	Эрүүл үрс төвийн хэмжээнд дараах сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: Эмнэлгийн мэргэжилтний	100%

						харилцаа хандлага • “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба үнэ цэнэ” • Эмнэлгийн мэргэжилтний харилцаа ба хүнлэг үйлчилгээ” сэдэвт сургалтуудыг зохион байгуулан давхардсан тоогоор 72 ажилтныг хамруулан ажилласан байна. Мөн байгууллагын эмч сувилагч нар багц цагийн сургалтын 2кр ёс зүйн сургалтад цахимаар болон танхимаар хамрагдсан байна.	
1.6.2.	“Монгол бичиг”-ээр унших бичих, чадвараа сайжруулахад дэмжлэг үзүүлэх дээшлүүлэх	1.000.0 БТ	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	30	30	Тус сэргээн засах төв нь Төрийн албан бичгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Үндэсний бичгээр хөтлөх болсон"-той холбогдуулан тус төвийн албан хаагчдыг нэг удаагийн Үндэсний бичгийн сургалтад хамруулаад байна. Мөн Архив бичиг хэргийн ажилтан М.Энхчимэг нь Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын танилцуулга, хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй /3 удаагийн сургалт/ Архивын үйл ажиллагааны нийтлэг журмын танилцуулга, хадгаламжийн нэгж, бүрдүүлэх арга зүй “eDoc” системийн шинэчлэгдсэн хувилбар "eDoc" системийг "V-0.1.9.3" шинэчилсэн хувилбарт шилжүүлэх тухай" сургалтуудад хамрагдсан. Монгол хэлний тухай хуулийн дагуу төрийн албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулж байна. Монгол бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, монгол бичгээр цахим бичвэр боловсруулах чадавхтай	98%

						мэргэжилтнүүдийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол бичгээр бие даан суралцахад албан хаагчдад зориулан Монгол бичгийн 2 дүрмийн толийг худалдан авч номын санд байршуулсан. Албан бичиг боловсруулахдаа Edoc систем тогтмол ашигладаг 15 албан хаагч монгол бичгээр шивэх ажлыг суралцаж байна.	
			Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөн явуулсан хувь	100%	100%	Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2."...төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна", 24 дүгээр зүйлийн 24.2."...2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө", Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудасны эх загварыг Нийслэлийн архивын газрын албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчаар хянуулж баталгаажуулан, хэвлүүлэх зөвшөөрөл авч хэвлүүлэн нь албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулж байна. 2026 оны хагас жилээр төвийн даргын 42 тушаал, 28 албан бичгийг хөрвүүлээд байна.	100%

1.6.3.	Дээд газраас ирсэн судалгаа, тайлан, мэдээ, тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж өгч ажиллана.	-	Хугацаанд нь шийдвэрлэсэн бичгийн тоо	90	90	Байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системийг нийт 15 албан тушаалтан тогтмол ашиглаж байна. Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системийн ашиглалтын талаарх сургалтыг албан хаагчдад зохион байгуулж, шийдвэрлэлт, боловсруулалт стандартын зөрчлийг арилгуулсан. Системд ирсэн бичгийг хугацаа хоцроохгүй шийдвэрлэн, хяналт тавин ажиллаж байна. Байгууллагын баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бичиг хэрэгт хүлээн авч бүртгэн одоогоор нийт 122 ирсэн бичиг хугацаа хоцроохгүй шийдвэрлэн ажиллаж байна. “eDoc” системээр 39 албан бичиг боловсруулан илгээн ажилласан байна.	50%
			Хугацаа хоцроосон тайлангийн тоо	0	0	Хугацаа хоцроосон тайлан байхгүй байна.	100%

1.6.4.	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заалтад Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж заасан тул эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж ажиллана.	-	Хяналт үнэлгээ хийгдсэн тоо	-	1	Эрүүл Үрс хүүхдийн сэргээн засах төв нь мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, (галт хана, нөөцлөх систем, UPS гэх мэт) тоног төхөөрөмж болон мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн одоогоор байхгүй байгаа хэдий ч мэдээллийн системийн өдөр тутмын ажиллагааг хангах серверийн болон сүлжээний аюулгүй байдлын тоног төхөөрөмжүүдийг үе шаттайгаар худалдан авч суурилуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан мэргэжилтэн ажиллуулах эсвэл энэ чиглэлээр гэрээт үйлчилгээний компанитай хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв нь 2026 оны хагас жилийн байдлаар өөрийн байгууллагын онцлогт тохируулан төвийн ашиглагдаж буй 22 компьютер бүрийг нэгдсэн кодтой болгон ажиллаж байна. Байгууллагын тасгийн эрхлэгч нарын ашиглагдаж буй компьютер өөр кодтой бусад үйл ажиллагаанд ашиглагдаж буй компьютер бүр нэгдсэн кодтой ашиглагдаж байна. Мөн кибер аюулгүй байдлыг хангахаар төвийн хэмжээнд 2026 ондоо дотоод сүлжээтэй, 1 сервер компьютертой болохоор ажиллаж байна. Дотоод хяналтын багтай хамтран тус шалгалтыг 1 удаа хийж ажилласан болно.	40%
			Сүлжээний хангалт, тоног төхөөрөмжийн тоо	1	1	Эрүүл үрс төвийн хэмжээнд одоогоор дотоод сүлжээгүй цаашдаа болохоор ажиллаж байна.	0%
1.6.5.	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эрх	-	Эрсдэлийн үнэлгээний тоо	-	1	Үнэлгээ хийгдээгүй болно.	0%

	бүхий байгууллагаар хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.		Эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	-	100	Үнэлгээ хийгдээгүй учир зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа болно.	0%
1.6.6.	Сэргээн засах төвийн холбогдох албан тушаал бүхий хүмүүс төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын хуулийн дагуу ХАСХОМ-г хуулийн хугацаанд бөглөн дээд удирдах байгууллагаас зохион байгуулагдсан сургалтад хамрагдан ажиллана.	-	ХАСХОМ-ий хугацаанд нь хүргүүлсэн ажилчдын хувь	100%	100%	Нийслэлийн засаг даргын тамгын газраас ирсэн албан бичгийн дагуу 2026 оны 01 сарын 25-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “2025 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг” сургалтад байгууллагын дарга Ш.Саруултуяа, нягтлан бодогч Г.Ариунжаргал, Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Л.Эрдэнэбулаг, Захиргаа санхүүгийн албаны дарга Т.Алтанзул нийт 4 албан хаагч цахимаар сургалтад хамрагдсан. Мөн ХАСХОМ хугацаанд нь бөглөн баталгааны хуудсыг НЭМГ-т хүргүүлэн ажилласан. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулагдсан ЭБАТ-уудын сургалтад 2026.05.12-ны өдөр төвийн дарга Ш.Саруултуяа, хүний нөөцийн менежер М.Энхчимэг нар цахимаар бүрэн хамрагдсан.	100%

1.6.7.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд албан хаагчдыг хамруулан авлигын эсрэг, зөрчлийн талаарх сургалтыг ажлын байранд зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, авлига болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын эсрэг болон зөрчлийн талаарх сургалтыг ажлын байранд зохион байгуулсан. Сургалтаар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын талаар мэдээлэл өгч, албан хаагчдад тулгарч болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг танилцуулсан. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлан ажиллаж байна. /мэдээллийн самбар, цахим хуудас, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал гэх мэт/ Эрүүл үрс төвийн 36 албан хаагчдад 1 удаагийн сургалт зохион байгуулан байгууллагын фэйж хуудас болон хэвлэмэл материал ашиглан авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн ажлын байр болон үйлчлүүлэгчдийн өрөөнд 1-110 утасны мэдээллийг байршуулсан.	100%
--------	--	---	--	------	------	---	------

1.6.8.	Ажлын байрны орчин, нөхцөлөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар төвийн хэмжээнд сургалтыг мэргэжлийн байгууллагаар зохион байгуулж, ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Зохион байгуулсан сургалтын тоо	1	1	Эрүүл үрс төвийн хэмжээнд мэргэжлийн байгууллагаар хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт одоогоор зохион байгуулаагүй болно. Төвийн хоол үйлдвэрлэлийн ажилчдад төвийн захиргаа аж ахуйн тасгийн эрхлэгч тогтмол зөвлөгөө өгч танилцуулан ажилладаг болно.	30%
--------	--	---	---------------------------------	---	---	---	-----

1.6.9.	Шинэчлэн батлагдсан “Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн” хэрэгжилт, шинээр гарч буй хууль дүрэм журмыг байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулна.	-	Сургалтын тоо	2	2	Нийслэлийн Архивын газраас дүүргийн Засаг даргын Тамгын газар, байгууллага, хороодын удирдлага, албан хаагчдад албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системийн шинэчлэгдсэн хувилбарыг танилцуулах сургалтад 3-н үе шаттайгаар зохион байгуулагдаж тус сургалтад удирдах албан тушаалтнууд, ажилтан, албан хаагчид, бичиг хэргийн зэрэг 14-н албан хаагчид хамрагдлаа. Сургалтын үеэр шинэ системийн онцлог, ажиллагааны дараалал, ашиглалтын заавар, албан хэрэг хөтлөлтийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх шинэчлэгдсэн чиглэлийн талаар мэдээлэл авсан юм. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1692 дугаартай Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" системийг "V-0.1.9.3" шинэчилсэн хувилбарт шилжүүлэх тухай" захирамжийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 2026 оны 04 дүгээр сарын 20-оос шинэ системд бүрэн шилжин ажиллаж байна. Мөн “Үндсэн эх үүсвэрийн жагсаалт”-ын дагуу 2023-2025 онд нөхөн баяжилт хийсэн байгууллагууд төрийн архивд хүлээлгэн өгсөн баримтын батлагдсан дансыг байгууллагын архивын систем (Archive eDoc)-д шивж оруулан цахимжуулах сургалтад 2026.04.09-ны өдөр бичиг хэргийн ажилтан М.Энхчимэг хамрагдан. Тус сэргээн засах төв 2026 оны 05 сарын 19-ны өдөр 2023 онд нөхөн баяжилт хийж төрийн архивд хүлээлгэн өгсөн 64 баримтын батлагдсан дансыг байгууллагын архивын систем (Archive eDoc)-д шивж оруулан цахимжуулж бүрэн дууссан болно.	100%
--------	--	---	---------------	---	---	---	------

			Хамрагдсан ажилчдын хувь	80.0%	85.0%	Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын танилцуулга, хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй /3 удаагийн сургалт/ -Архивын үйл ажиллагааны нийтлэг журмын танилцуулга, хадгаламжийн нэгж, бүрдүүлэх арга зүй -“eDoc” системийн шинэчлэгдсэн хувилбар "eDoc" системийг "V-0.1.9.3" шинэчилсэн хувилбарт шилжүүлэх тухай" -“Үндсэн эх үүсвэрийн жагсаалт”-ын дагуу 2023-2025 онд нөхөн баяжилт хийсэн байгууллагууд төрийн архивд хүлээлгэн өгсөн баримтын батлагдсан дансыг байгууллагын архивын систем (Archive eDoc)-д шивж оруулан цахимжуулах сургалт Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам стандарт сургалт зэрэг хагас жилийн байдлаар дотоодын 2, гадаад үйл ажиллагааны 6 сургалтуудад давхардсан тоогоор 37 албан хаагчдыг хамруулан ажиллаж байна.	100%
1.6.10.	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн хүрээнд багтаан төсвийг мэдээг сарийн 1ний өдөр НЭМГ-ийн мэргэжилтэнд хүлээлгэн өгч баталгаажуулсан.	50%
1.6.11.	2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	2027 оны төсвийн төсөөллийн заасан хугацаанд нь хүлээлгэн өгөхөөр бэлтгэн ажиллаж байна.	30%
1.6.12.	2026 оны тогтмол зардлын төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд хүргүүлэн	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Тогтмол зардлын сүүлийн 3 жилтэй харьцуулан үр дүнтэй судалгаа гаргаж тооцоолж ажиллана.	50%

	ажиллана.						
1.6.13.	Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Тендерийн худалдан авалт байхгүй	100%
1.6.14.	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд тайлагнах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 1 дотор НЭМГ төсвийн мэргэжилтэнд өгч баталгаажуулан авсан нийт 12 мэдээнээс 6 мэдээ бэлтгэсэн.	50%
1.6.15.	2025 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөө	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	2025 оны санхүүгийн тайлангаар илэрсэн 2 акт төлбөрийг барагдуулж төрийн санд төвлөрүүлсэн 4 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна,	80%

	боловсруулан хэрэгжүүлэх						
Зорилго 2. Хүүхдийн эрүүл мэнд түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, үнэлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна.							
2.1.	Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд: Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг эрчимжүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулан, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна.						
2.1.1.	“Хүн төв”-тэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бий болгох загварчлалын бэлтгэл ажлыг хангана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	30	Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв 2026 оны хагас жилийн байдлаар 2010 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд тус төв нь хүн төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тогтмол үзүүлэн ажиллаж байна. Сэргээн засах эмчилгээ гэдэг нь цогц тусламж үйлчилгээ бөгөөд - Үйлчлүүлэгч ба түүний ар гэр - Сэргээн засахын эмч - Уламжлалтын эмч - Хүүхдийн эмч - Сэргээн засахын сувилагч - Хөдөлгөөн засалч - Хөдөлмөр засалч - Хэл засалч - Туслах сувилагч - Хоол зүйч тогооч нарын хамтаар тусламж үйлчилгээг хүртээмжтэй хамтран хүргэн ажиллаж байна. Төвийн хэмжээнд сэтгэл зүйч байхгүй ч хүүхдийн мэдрэлийн эмч, хүүхдийн эмч нар эцэг эх асран хамгаалагчтай хамтран сэтгэлзүйн өөрчлөлтөөс улбаалсан бие махбодын эмгэг илэрсэн хүүхдүүдэд зөвлөгөө өгч хамтарсан уулзалтыг зохион байгуулан ажилладаг. Мөн манай сэргээн засах төв нь дараах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд: • Орчны нөхцөлийг үйлчлүүлэгчид ээлтэй болгон үйлчлүүлэгчийн	40%

						аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавин ажилладаг. - Сэтгэлзүйн болон харилцааны тал дээр анхаарч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ар гэртэй харилцахад сэтгэл санааны байдлыг үнэлэн зөвлөн хүн бүрд өөр өөрийн гэсэн амьдралын ачаалал, сэтгэл зүйн дарамт байдаг тул түүнийг даван туулахад харилцагч нарын зүгээс харилцан ойлголцол, уян хатан байдлыг эрхэмлэх шаардлагатай байгааг тайлбарлан зөвлөн ажиллаж байна. - Сэргээн засах эмчилгээний явцад үйлчлүүлэгчид үйлчилгээний урсгалын чирэгдэлгүй ойлгомжтой байлгах тал дээр анхааран үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэх үйл явцын зураглалыг гарган ажиллаж байна.	
2.1.2	Хүүхэд өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	-	Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээний тоо	2	2	Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв нь өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үүднээс нийслэлийн ерөнхий боловсролын 12 болон 153-р сургуулийн ахлах ангийн сурагч нарын дунд миний мэдэх сувилагч эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулан сувилагч мэргэжлийн үнэ цэнэ, онцлог, давуу тал, сул талын талаар өөрсдийн мэдэх өнцгөөр эссэ бичүүлэн төвийн нийт ажилчид болон ухаалаг системийн тусламжтай шалган шалгаруулан эхний 3н байр бүхий сургууль тус бүрийн 6 сурагчдыг шалгаруулан хэвтэн эмчлүүлэх эрхийн бичиг болон мөнгөн шагналаар урамшуулан ажиллаа. Эссэ бичлэгийн уралдаанд 2 сургуулийн	80%

						нийт 119 эссэ ирж хүүхдүүд идэвх санаачилгатай оролцсон арга хэмжээ боллоо. “Эрүүл үрс” хүүхдийн сэргээн засах төвөөр үйлчлүүлж буй иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг байгууллагын цахим хуудас болон тараах материал ашиглан тасаг нэгжийн онцлогт тохируулан хийсэн. Сургалтын давтамжийг нэмэгдүүлэн 9 төрлийн сургалтын сэдвүүдээр зөвлөмж гарган тасаг, нэгжид байршуулан 2026 оны хагас жилийн байдлаар нийтдээ 790 ширхэг тараах материал тараасан. Үүнд: • Осол гэмтлээс сэргийлэх зөвлөмж-40ш • Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх-50ш • Улаанбурхан өвчнөөс сэргийлэх -50ш • Бариа эмчилгээний ач холбогдол-200ш • Гар хөл амны өвчин-30ш • Д витамин дутал-35ш • Хахалтын үед үзүүлэх тусламж-30ш • Хавтгай тавхай-30ш Эрүүл Үрс хүүхдийн сэргээн засах төвийн танилцуулга-325ш зөвлөмж, гарын авлагыг иргэдэд тараасан байна.	
			Амны хөндийн эрүүл мэндийн сургалтад хамрагдсан эцэг эх асран хамгаалагчдын тоо	50	60	Үзлэгийн ажлыг одоогоор зохион байгуулаагүй байна.	0%
2.1.3.	Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсролыг	-	Зохион байгуулсан сургалтын тоо	4	4	Эрүүл Үрс хүүхдийн сэргээн засах төв нь 2026 оны 04-р сарын 21,21-ны өдрүүдэд	50%

	дээшлүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулна.					Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан “Эрүүл мэндийг дэмжих нээлттэй хаалганы өдөрлөгт” оролцсон.Тус өдөрлөгөөр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдлыг таниулах, эрүүл амьдралын хэв маягийг түгээн дэлгэрүүлэх зорилготой гурван өдрийн турш олон нийтэд нээлттэй зохион байгуулагдсан. • Өдөрлөгийн 1-р өдөр: Хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, хийгдэж нийт 100 хүүхдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. • Өдөрлөгийн 2-р өдөр: Уламжлалт анагаах ухааны чиглэлээр нээлттэй хаалганы өдөрлөг зохиогдож Эрүүл Үрс хүүхдийн сэргээн засах төвийн 3 уламжлалтын эмч үзлэг оношилгоо хийж ажилласан.	
			Хамрагдсан иргэдийн тоо	40	40	Төвийн эмч нар нийт 250 иргэнд үзлэг оношилгоо хийж, 2 өдрийн хугацаанд нийт 350 иргэнийг хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.	100%
2.1.4.	СХД-т байрлаж буй хувийн болон улсын асрамжийн газартай гэрээ байгуулан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгоо, эмчилгээнд хамруулна.	-	Гэрээ байгуулсан асрамжийн газрын тоо	1	2	Эрүүл үрс төв нь 2026 оны 1 дүгээр улиралд СХД-ийн 40-р хороонд байрлах Кристина Нобелийн Хүүхдийн Сангийн дэргэдэх “Нархан” хүүхдийн асрамжийн газартай гэрээг сунган ажиллаж байна.	50%
			Эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	81	50-90	2026 оны 1 дүгээр улиралд “Нархан” хүүхдийн асрамжийн газрын 35 хүүхдэд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо хийн, хэвтэн эмчилгээнд хамруулсан байна.	50%

2.1.5.	Хүүхэд өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан үе шаттай сургалт зохион байгуулан ажиллана.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	Эрүүл Үрс төв нь 2026 оны 03-р сарын 17-ны өдөр СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсийн Хүүхдийн асуудал хариуцсан ажилтан Дэслэгч Б.Тэлмэнтэй хамтран “Өөр байж болно” “Донтолтын цаана юу нуугддаг вэ?” сэдэвт сургалтыг төвийн хэвтэн эмчлүүлэх тасгийн өсвөр насны 15 үйлчлүүлэгч нарт зохион байгуулсан. 2026 оны 02 сарын 06-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 12-р сургуулийн 5е ангийн 41 сурагчдад, мөн Нийслэлийн ерөнхий боловсролын 153-р сургуулийн 12а ангийн 47 сурагчдад нийт 2 сургуулийн, 2 бүлгийн, 88 сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгон ажилласан.Сургалтаар томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлааг дэмжих зөв дадал хэвшил, халуун аарц болон амин дэмийн хэрэглээний ач холбогдлын талаар мэдээлэл өгч хүүхдийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр “Эрүүл үрс төв”-ийн их эмч нар удирдан зохион байгуулан ажилласан.Сургалтын төгсгөлд хүүхдүүдэд дархлааг дэмжих зорилгоор халуун аарц, амин дэм, амны хаалт тараан өгч, зөвлөмж, мэдээллээр хангаж ажилласан. Мөн нийслэлийн ерөнхий боловсролын 12-р сургуулийн 5е ангийн нийт 41 сурагчдад, 153-р сургуулийн 12а ангийн 42 сурагчдад бусдын ялгаатай байдлыг буруушаах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, дарамтлах зэрэг үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх сургалтын зохион байгуулсан.	100%
2.1.6.	Хоол тэжээлийн цочмог дутлын эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд хамрагдсан байгууллагын (цэцэрлэг,	-	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо	7	5-10	Эрт илрүүлгийн үйл ажиллагаа нь 2026 оны 3 болон 5 сард зохион байгуулсан байна. Үүнд: ✓ Сонгинохайрхан дүүргийн	100%

	өдөр өнжүүлэх, асрамжийн газар) багш, эмч нарт хүүхдийн суурь өвчлөл болон түүнээс урьдчилан сэргийлэх тухай сургалт зохион байгуулна.					Нийслэлийн 294, 195, 244, 215, 260, 263, 214, 252, 261, 264, орбит шинэ хотхон цэцэрлэгүүд ✓ Чингэлтэй дүүргийн Нийслэлийн 102, 222, 246, 43 цэцэрлэгүүд, мөн 24 цагийн үйл ажиллагаа явуулдаг 83-р цэцэрлэгийг тус тус хамруулсан байна. Эдгээр цэцэрлэгийн эмч болон багш нарт тус илрүүлгийн ажлын зорилго үр дүнгийн талаар нийт 18 удаагийн сургалт зохион байгуулсан байна.	
			Сургалтад хамрагдсан багш, эмч нарын тоо	62	6	Тус үйл ажиллагааг өөрийн байгууллагын нөөц боломжид тулгуурлан зохион байгуулсан ба нийт 18 цэцэрлэгийн 53 бүлгийн 94 эмч багш нарт сургалт зохион байгуулан ажилласан байна.	100%
2.1.7.	Бага насны хүүхдийн суурь өвчлөл (хоол тэжээлийн цочмог дутал, цус багадалт, сульдаа)-г илрүүлэн, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх замаар эндэгдлийг бууруулна.	9.000.0 БТ	Хамтран ажилласан байгууллагын тоо	6	7	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төв нь жил тутамд 0-5 хүртэлх насны цэцэрлэгийн хүүхдүүдэд Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 сарын 17-ны А/379 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд цэцэрлэгийн насны хүүхдүүдийн хоол тэжээлийн цочмог дутагдал /ХТЦД/ болон хавтгай тавхай эрт илрүүлэх үзлэг, үнэлгээг зохион байгуулан ажилладаг. 2026 онд зөвхөн СХД төдийгүй өөрийн байгууллагад ирсэн цэцэрлэгийн хүсэлтийн дагуу ЧД-н цэцэрлэгүүдэд хоол тэжээлийн дутлыг илрүүлэх эрт илрүүлэн эмчлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна. Тус эрт илрүүлгийн үйл ажиллагаа нь 2026 оны 03 сарын 23-26-ны хооронд болон 05 сарын 04-аас 05 сарын 05-ны өдрүүдэд явагдсан бөгөөд Эрүүл үрс төвийн эмч,	100%

						сувилагч, туслах сувилагч нар нийлсэн нийт 16 ажилтны 3 баг ажилласан. Үүнд: ✓ Сонгинохайрхан дүүргийн Нийслэлийн 294, 195, 244, 215, 260, 263, 214, 252, 261, 264, орбит шинэ хотхон цэцэрлэгүүд ✓ Чингэлтэй дүүргийн Нийслэлийн 102, 222, 246, 43 цэцэрлэгүүд, мөн 24 цагийн үйл ажиллагаа явуулдаг 83-р цэцэрлэгүүдэд үзлэг илрүүлэг зөвлөгөө, хяналтад хамруулах ажлыг зохион байгуулсан.	
			Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо	2125	2135	Тус үйл ажиллагааг өөрийн байгууллагын нөөц боломжид тулгуурлан зохион байгуулж, нийт 18 цэцэрлэгийн 53 бүлгийн 1508 хүүхдийг үзлэгт хамруулан ажиллаа. Үүнээс 762 нь эрэгтэй, 746 нь эмэгтэй хүүхдүүд хамрагдсан байна.	60%
			Хүнд тураал бүхий эмчилгээнд хамрагдаж эрүүлжсэн хүүхдийн тоо/хувь	20/71%	26/75%	Эрт илрүүлгийн ажлаар нийт хүүхдүүдийн 3,2% нь хоол тэжээлийн хүнд болон хүндэвтэр дутагдалтай хүүхдүүд илэрсэн байна. Тус хүүхдүүдээс 23,4% эмийн эмчилгээ болон эмчилгээний хоолоор эмчлэгдэж байна. Одоогоор эмчилгээний үр дүн бүрэн тодорхойлогдоогүй эхний болон 2 дахь давтан үзлэгээр биеийн жин 300-900гр нэмэгдсэн байна. Хоол тэжээлийн хүнд хүндэвтэр дутал бүхий хүүхдийг эмчилгээний хоолоор эмчлэхэд нөлөөлөх хүчин зүйл, эцэг эх, эмчийн хамтын үйл ажиллагаа шаардлагатай учир 3-4 сарын дараа үр дүнг тооцох боломжтой.	40%
2.1.8.	Хүүхдийн сэргээн засах төвийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог	-	Цахим хуудасны дагагч тоо	10000	10100	Эрүүл үрс төв нь байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих	100%

	боловсронгуй болгох, мэдээллийн цахим хуудсаар дамжуулахад анхаарч баяжуулалтыг тогтмолжуулна.					мэдээ, мэдээллийг тогтмол бэлтгэн 2026 оны хагас жилийн байдлаар 11 мянган дагагчтай болсон байна.	
			Мэдээллийн тоо	250	260	Төвийн цахим хуудсаар дамжуулан 179 мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгон ажиллаж байна. Үүнээс like-1639,/ таалагдсан/ share-569 /цааш түгээсэн/ үзүүлэлттэй байна.	60%
2.1.9.	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аян зохион байгуулж иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлнэ.	-	Аяны мэдээлэл хүрсэн иргэний тоо	200	250	Эрүүл үрс төв нь осол гэмтлээс сэргийлэх нөлөөллийн аян 2026 оны I/15-II/15-ны өдрүүдэд зохион байгуулан 61 үйлчлүүлэгчийн хамруулан ажиллаа. Тус аяны хүрээнд байгууллагын дотоод болон гадна орчны эрсдэлийг үнэлж, халтиргаа гулгааг арилгах, анхааруулга санамж байршуулах, үйлчлүүлэгчийн 18 орны 2 хашлагатай байсныг шийдвэрлэн бүх орыг хашлагатай болгох зэрэг аюулгүй байдлыг хангах 4 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. Мөн байгууллагын 30 ажилтан болон хэвтэн эмчлүүлэгч 31 иргэнд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт орж, цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан сэрэмжлүүлэг постер, видео бичлэгүүдийг олон нийтэд түгээн ажилласан. Төвийн хэмжээнд бүртгэгдсэн тохиолдолд осол гэмтэл болон аюулгүй ажиллагаа алдагдсан тохиолдол бүртгэгдээгүй байгаа болно. Цаашид учирч болох эрсдэлийг илрүүлэн сэргийлэн ажиллахаар ажиллаж байна.	20%
2.1.10.	Албан хаагчид өөрийн хүсэлтээр мэргэжил боловсролоо дээшлүүлэн суралцах үед хөдөлмөрийн дотоод журамд	-	Мэргэшил дээшлүүлэхээр суралцагчдын тоо	6	6	Тус төв нь MNS 6801:2019 стандартад заасан орон тооны хязгаар, мэргэжлийн чиглэлийн дагуу хүний нөөцөө төлөвлөн ажиллаж байна. Одоогийн байдлаар нийт мэргэжлийн тусламж үйлчилгээний бүрдүүлэлт 80.7%-тай байгаа бөгөөд 2025	100%

	зааснаар дэмжлэг үзүүлэн ажиллана.				онтой харьцуулахад олон төрлийн мэргэжлээр орон тоог нөхөж, чадавхыг нэмэгдүүлсэн.Тухайлбал, 2025 онд орон тоо нь бүрдээгүй байсан сувилагч, нийгмийн ажилтан, төрөлжсөн хүүхдийн эмч зэрэг чиглэлүүдэд 2026 онд зохих түвшинд хүргэн ажиллаж байна. <i>Эмч сувилагч нарын төрөлжсөн мэргэшил, зэрэг хамгаалалт:</i> Эрүүл Үрс төв нь эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг нарийн мэргэжлээр төрөлжүүлэн сургах, чадавхжуулах,зорилтыг шат дараатай хэрэгжүүлж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар тус төвийн-1 эмч “Хүүхдийн Ахлах зэрэг хамгаалсан бол Хүүхдийн 2 их эмч, 2 сувилагч төгсөлтийн дараах төрөлжсөн нарийн мэргэшлийн сургалтад амжилттай хамрагдлаа. Үүнээс 1 хүүхдийн эмч мэдрэлийн эмчээр, хүүхдийн дүрс оношилгооны эмчээр 1 эмч мэргэшиж төгссөн. 2026 ондоо өөрийн байгууллагын эмч нарыг улам мэргэшүүлэхээр зорин ажиллаж байгаа төдийгүй сэргээн засахын нарийн мэргэжлийн эмч, хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийг бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Тиймээс манай төвийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх боломжтой юм. 2025 оны байдлаар төвийн хэмжээнд 5 сувилагчтай байсан бол 2026 оны байдлаар тусгай мэргэжлийн 3 сувилагч амжилттай төгсөж 8 сувилагчтайгаар ажиллаж байна. Тус сувилагч нараас 2 сувилагч төрөлжсөн мэргэжлийн сургалтад суралцаж байна. Үүнд: • Хүүхдийн сувилагч -1 • Сэргээн засах эмчилгээний	
--	---------------------------------------	--	--	--	--	--

						сувилагч -1 суралцаж байна. Мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн, дээшлүүлэх сургалтаас гадна, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, боловсролын зэргийг ахиулах чиглэлд тодорхой ахиц гарч, 2026 онд тус төвийн 4 эмч Анагаах ухааны магистрантурт суралцаж байна. 1 эмч магистр зэрэгтэй болсон байна. Хүүхдийн сэргээн засах төвийн хэмжээнд хүний нөөцийн чадавх 2025 онтой харьцуулахад тогтмол нэмэгдэж байгаа төдийгүй 3 сувилагч 'Ач' АУИС-д Нийгмийн эрүүл мэндийн судлаачийн мэргэжлээр суралцаж байна. Ингэснээр хүүхдийн сэргээн засах төв нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртээмжтэй хүргэн, судалгаа шинжилгээг илүү боловсронгуй зохион байгуулах боломжтой болно. Тус төв нь 2025 онд 5 асрагчтай үйл ажиллагаа явуулж байсан бол 2026 онд асрагч нар мэргэшин туслах сувилагчаар суралцан амжилттай төгссөн байна. Иймээс эмнэлгийн мэргэжилтний тоо нэмэгдэн эмч болон сувилагчийн харьцаа 1:1.3 болсон байна. Цаашид хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах үүднээс дутагдалтай орон тоо бүхий ажлын байранд дотоодоосоо суралцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	
2.1.11.	Худалдан авах үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод	-	Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж шилэн дансанд байршуулсан хувь	100%	100%	Бараа бүтээгдэхүүн худалдан авах ажиллагаа төсвийн хуваарийн дагуу сар бүр тогтмол хийдэг байна	40%

	шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэн ажиллана.						
2.1.12.	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Дотоодын үйлдвэрээс бараа, материал худалдан авах” 90 дүгээр тогтоолын дагуу чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авч ажиллана.	3.500.0 БТ	Чанар стандартын, үнийн харьцуулсан судалгааны дүн	1	1	Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг дотоодын үйлдвэрлэгч аж ахуй нэгж байгууллагаас чанар үнийн дүнгийн 1 удаагийн судалгаа авч манай эрүүл ахуйн стандартад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг сонгож гэрээ байгуулан худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.	50%
2.2.	Зорилт 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд удирдлага манлайллыг нэмэгдүүлэх замаар зэмлэн буруутгахгүй дадлыг төлөвшүүлэн, аюулгүй байдлыг ханган ажиллана.						
2.2.1.	Эмчилгээ, үйлчилгээнд гарсан тохиолдолд (алдаа зөрчилд) системийн анализ хийж, зөвлөмж өгөх, зөвлөмжийн гүйцэтгэлийн хяналтыг сайжруулна.	-	“Тохиолдлын сан”-д бүртгэгдсэн эмнэлзүйн тохиолдлын тоо	13	15	Төвийн хэмжээнд 2024 оны А/112 тоот тушаал батлагдсантай холбогдуулан төвийн даргын А/33 тоот тушаалыг шинэчлэн батлан ажилласан. Тус тушаал шинэчлэгдсэнтэй холбогдуулан төвийн хэмжээд тохиолдол хэрхэн бүртгэх мэдээлэх, тохиолдлыг яагаад бүртгэх шаардлагатай талаар сургалт тогтмол зохион байгуулан ажилласан. Сургалт зохион байгуулсантай холбоотойгоор ажилчид тохиолдлыг мэдээлэх нь нэмэгдсэн байна. Байгууллага өөрсдийн хэмжээнд 2020 оноос тохиолдлын санг үүсгэн бүртгэн түүний дагуу үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна. Хагас жилийн байдлаар нийт 11 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд : - Алдах дөхсөн буюу 1А-5	80%

						- Тохиолдол буюу 1Б – 3 - 2 буюу алдаа – 3 бүртгэгдсэн байна. 2 буюу эмнэлгийн алдаан дээр хэлэлцүүлэг зохион байгуулан ажилласан.	
			Тохиолдолд суурилсан хэлэлцүүлгийн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	96%	100%	2026 оны хагас жилийн байдлаар 2 хэлэлцүүлэг, таагүй 2 тохиолдлыг 2 багаар хэлэлцүүлэг хийж 18 хүн оролцож 2 зөвлөмж гарган түүний мөрөөр уламжлалт эмчилгээ болон яаралтай түргэн тусламжийн талаар сургалт зохион байгуулан гардан үйлдлийн шалгалт авч үр дүнг тооцон хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд давтан шалгалт авах үйл ажиллагаа хэрэгжүүлсэн.	100%
2.2.2.	Эрүүл аюулгүй орчин бүрдүүлэн гадаад болон дотоод орчны эрсдэлийг үнэлэн түүнийг шийдвэрлэн ажиллана.	-	Эрсдэлийн үнэлгээ хийсэн тоо	2	2	Эрсдэлийн удирдлагын багийг төвийн даргын 2021 оны А/19 тоот тушаалаар орон тооны бус 5 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, эрсдэл тохиолдлыг чанарын баг хариуцан ажиллаж байна. 2026 нийт 9 чиглэл 31 ажлыг төлөвлөн ажилласан. Хагас жилийн байдлаар давтан үнэлгээ хийж ажилласан байна.	50%
			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	2	Тасаг, нэгжид эрсдэлийн үнэлгээ хийж, тасаг, нэгжид дотоод хяналт үнэлгээг тогтмол хийсэн. ✓ Эмчилгээ, оношилгоо, тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэл ✓ Халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл ✓ Эм зүй, эм био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдалтай холбоотой эрсдэл ✓ Тоног төхөөрөмж, санхүү бүртгэл, мэдээлэлтэй холбоотой эрсдэл ✓ Гадаад, дотоод орчинтой холбоотой эрсдэл	70%

					Нийт 31 эрсдэлийг тодорхойлж бууруулах ажил зохион байгуулж ажилласан. Эрсдэлийн үнэлгээний дагуу хэрэгжүүлсэн ажил: - Яаралтай тусламжийн шүүгээний бэлэн байдлыг ханган, өндөр эрсдэлт эмийн тушаалыг батлуулах, эмийн нөөцийг бүрдүүлэн ажилласан. - Гар угаах халдваргүйжүүлэх гардан үйлдлийн хяналтыг тушаалаар 2 удаа авагдах байсныг төвийн онцлогт тохируулан улирал тутамд үнэлэн ажиллаж гар угаах халдваргүйжүүлэх чадвар нэмэгдсэн. - Хоолны хордлого үүсэхээс сэргийлэн хоол үйлдвэрлэлийн явцад хяналт тавин, дээж авалт, халдварыг сэргийлэлт хяналтын журмыг баримтлан ажиллаж байна. - Үйлчлүүлэгчийг халуун хоол цайнд түлэгдэхээс сэргийлж халуун болон идэхэд тохиромжтой хоолны тэмдэг тэмдэглэгээг тасаг нэгжид байршуулан ажиллаж байна. - Эмч эмнэлгийн ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдүүлэн ажиллах сургалтыг 1 удаа орсон байна. - Төвийн хүрээнд мөрдөгдөж буй тушаал, журам, заавар болон шийдвэрийг танилцуулж төвийн нийт ажилчдад сургалт зохион байгуулсан. - Эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчийн хувийн болон эрүүл мэндийн мэдээллийн нууцыг хадгалах, мэдээллийн аюулгүй	
--	--	--	--	--	--	--

						байдлыг хангах чиглэлээр холбогдох хууль, дүрмийн хүрээнд эмнэлгийн бүх компьютерыг бүрэн коджуулан ажиллаж байна. Дүгнэлт. 2026 оны эхний үнэлгээнд: • Ноцтой эрсдэл 6 буюу 19.3% • Өндөр эрсдэл 21 буюу 67.7% • Дунд эрсдэл 2 буюу 6.5% • Бага эрсдэл 2 буюу 6.5% тус тус эзэлж байсан. 2026 оны хагас жилийн үнэлгээнд: • Ноцтой эрсдэл 4 буюу 12.9% • Өндөр эрсдэл 17 буюу 54.8% • Дунд эрсдэл 7 буюу 22.6% • Бага эрсдэл 3 буюу 9.7% тус тус эзэлж байна Ноцтой, өндөр эрсдэлийг 6.4-12.9%-аар бууруулан ажилласан байна	
2.3.	Зорилт 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: Эрүүл мэндийн байгууллагуудын барилга, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ нөхөн хангалтыг ажлыг зохион байгуулна.						
2.3.1.	Төвийн шинэ 80 ор бүхий барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	8,118.7 УТ	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	80%	100%	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвийн барилга, 80 ор бүхий ажлыг Элбэг гүн ХХК гүйцэтгэн барилгын угсралтын ажил бүрэн гүйцэтгэсэн одоогоор улсын комисс ажиллахаар хүсэлт өгсөн байна.	100%
2.3.2.	Тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж нэр төрлийн нэмэгдүүлэн ажиллана.	1,422.36 НТ	Нийлүүлэх тоног төхөөрөмжийн тоо	100	120	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийг 2025 оны I-II улиралд төвийн эмчилгээний болон захиргаа аж ахуйн тасаг хамтран гаргаж ажилласан. 2025 оны 3-р сард төрийн худалдах авах ажиллагааны газар нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулагдан 2026	100%

						оны хагас жилийн байдлаар нийт 9 багц тоног төхөөрөмжийн тендер зарлагдан бүх тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.	
2.3.3.	Барилга байгууламжийн засвар, инженер техникийн нөхцөл байдлыг сайжруулах, шинэчлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж төвийн тасаг нэгжүүд, барилга байгууламжид урсгал ба их засвар хийх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	14.000 .0 БТ	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь	93%	100%	2026 оны хагас жилийн байдлаар барилга байгууламжийн засвар, инженер техникийн нөхцөл байдлыг сайжруулах, шинэчлэх чиглэлээр төвийн тасаг нэгжүүд болон барилга байгууламжид урсгал засварыг жилд 1–2 удаа тогтмол хийж үйлчилгээг төлөвлөгөөний, дагуу зохион байгуулж, ашиглалтын явцад үүссэн цахилгаан, сантехник, гэрэлтүүлэг болон ариун цэврийн тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг тухай бүр арилган ажиллалаа. Тайлант хугацаанд гал тогооны цахилгаан пийшингийн засвар үйлчилгээ хийж, тасаг нэгжүүдийн гэрэлтүүлгийг шинэчлэн, цонх болон агааржуулалтын хоолойг хамгаалалтын тороор бүрэн тоноглогсон. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд тогтмол үзлэг, шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилган, шаардлагатай засвар үйлчилгээ, шинэчлэлийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн.	50%
2.3.4.	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах АЗ сертификатын суурь мэдлэг олгох сургалтад 1 ажилтныг хамруулан ажиллана.	500.0 БТ	АЗ сертификат авсан хүний тоо	1	1	“Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх-АЗ” буюу тендерийн сургалтад албан хаагчдыг хамруулахаар сургалтын бүртгэл, болон шалгалтад бэлтгэх үйл явцыг дэмжин ажиллаж байна.	100%
2.3.5.	Сэргээн засах төвийн хэмжээнд шаардлагатай	-	Эмийн нөөц хангалт хувь	100%	100%	Эрүүл үрс төв нь Төвийн даргын 2023 оны А/34 тоот тушаалаар “Яаралтай	100%

	эм тариа, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангана.				тусламжийн нэгжийн ажиллах журам, эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт”-ыг баталгаажуулан мөрдөж байна. Яаралтай тусламжийн өрөөг гаргаж, шаардагдах багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр иж бүрэн ханган ажиллаж байна.Яаралтай тусламжийн эм тарианы бэлэн байдал, нөөцийг хянах зорилгоор хяналтын хуудсыг боловсруулан, "Хугацаат эмийн самбар"-аар сар бүр тогтмол хяналт тавьж байна. Мөн үндсэн тусламж, үйлчилгээг тасалдуулахгүй байх зорилгоор хүүхэд хүлээн авах хэсэг болон бусад эмчилгээний тасгуудад эмийн нөөцийг 2-3 сарын хугацаагаар багцаалан төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавин, нөхөн хангалтыг шуурхай зохион байгуулан ажиллаж байна.	
		Дотоод хяналтын тоо	4	4	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт явуулах нийтлэг журам”, мөн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын хүрээнд Нийслэлийн Хүүхдийн Сэргээн Засах “Эрүүл Үрс” төв нь байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна. Төвийн дотоод хяналтын баг нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/36 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан. Тус баг нь байгууллагын дотоод хяналт шалгалтын журам, удирдамж, хяналтын хуудсыг боловсруулж	50%

						батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. Дотоод хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулан ажиллаа. • Хоол үйлчилгээний чанар, аюулгүй байдал • Эмийн аюулгүй байдал, хадгалалт, хэрэглээ • Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт, бүрэн бүтэн байдал Шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэхэд байгууллагын үйл ажиллагаа 82.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, 14 хоногийн дараа давтан хяналт хийхэд гүйцэтгэл 95.7 хувьд хүрч, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой ахиц гарсан байна.	
2.4.	Зорилт 4. Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: Байгууллагын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны гүйцэтгэл, хяналтын тогтолцоог сайжруулж, оролцогч талуудын оролцоог ханган, хамт олны соёл ба манлайллыг хөгжүүлнэ.						
2.4.1.	Нэгж, хэлтсүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо (KPI)-г сайжруулна.	-	Биелэлтийн дундаж	-	85	Эрүүл үрс төвийн эмчилгээний тасагт ур чадварын үнэлгээнд KPI үнэлгээг нэвтрүүлэн одоогоор ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд KPI үнэлгээг нэвтрүүлснээр эмчилгээний ур чадвар, харилцааны чадвар, тусламж үйлчилгээний хүртээмж, гардан үйлдлийн чадвар зэргийг зөвхөн тоон үзүүлэлт төдийгүй гардан үйлдлийн хяналт, хамт олны үнэлгээтэй /360 degree feedback/ хавсран боловсруулан одоогоор 2 удаагийн үнэлгээ хийгдсэн ажиллаж байна.	50%
2.4.2.	Байгууллагын захиргааны болон албан ёсны тоон мэдээллийг сайжруулах,	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	80	Төвийн статистик тоон мэдээлэл болон чанарыг өвөрмөц үзүүлэлтийг ЭМТҮЧАБ-н багтай хамтран гаргаж байна. Одоогоор 8 үндсэн үзүүлэлтийг боловсруулан мэдээ	100%

	бэлэн байдлыг хангана.					тайланг тайлагнан ажиллаж байна. Нийслэлийн эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн тухай хууль, Статистикийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн салбарын статистикийн мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай” 611 дүгээр тушаалын дагуу харьяа 28 байгууллагын 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг НЭМГ-ын даргын 2025 оны А/205 дугаар тушаалаар баталсан хуваарийн дагуу дээрх байгууллагуудаас хүлээн авч нэгтгэн, цаасан тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвд цахимаар тайлангийн хугацаанд нь хүргүүлж, сарын мэдээний ЭМТ-501 тайлантай тулгаж хянуулсан. Хянуулсан тайланг Stata программд шивж оруулан, Hinfo3.0 программ дахь бааз мэдээлэлтэй тулгаж баталгаажуулан хянуулж тайлангаа 90,4% хамгаалан ажилласан.	
2.4.3.	Байгууллагын шаардлагатай дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангана.	-	Шинээр болон шинэчлэн батлуулсан дүрэм, журмын тоо	-	5	2026 оны хагас жилийн байдлаар төвийн даргын А11 тоот тушаалаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг байгуулах, А13 тоот тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам бүрэлдэхүүнийг тус тус шинэчлэн баталсан.	98%
2.4.4.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний үзлэгийн мэдээллийг хянах нэгдсэн цахим систем нэвтрүүлэх	5.0	Цахим систем нэвтрүүлсэн байна.	-	1	Эрүүл үрс төвийн хэмжээнд 2021 оноос “Аксис систем”-тэй хамтран өвчний түүхийг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна. Үйлчлүүлэгч аксис хэлбэрээр өвчний түүх хөтөлж ажилласан тохиолдолд үйлчлүүлэгчийн мэдээллийг манайх харах боломжтой байна.	10%
2.4.5.	80 ор бүхий хүүхдийн сэргээн засах төвийн бүтэц, орон тооны төслийг хүүхдийн тусламж үйлчилгээний	-	Батлагдсан нэгж тасгийн тоо	1	3	Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн 80 ортой өргөтгөлийн барилгын ажил 2026 оны 06 дүгээр сард ашиглалтад орохоор улсын комисст хүсэлтээ өгсөн. Үүний дагуу тус сэргээн засах төвийн бүтэц, орон	98%

	стандарт, ачааллын нормативд нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулсан байна.					тооны дээд хязгаарыг Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS6801:2019 стандартын дагуу нэмэгдүүлэх шаардлагатай тооцооллыг гарган Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/36 тоот тушаалын орон тооны дээд хязгаарыг батлах 03 дугаар хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтээ Нийслэлийн Эрүүл мэндийн газарт өгсөн боловч шинэ барилга ашиглалтад улсын комисс хүлээн аваагүй учир орон тооны тушаал батлагдаагүй байна.	
			Батлагдсан нийт орон тооны хувь	-	100%	Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төвийн 80 ор бүхий эмнэлгийн ор хоног, төсөвт орны зохион байгуулалтын бүтцийн орон тоо, албан тушаалын ангилал зэрэглэлийг өөрийн байгууллагын үйл ажиллагаанд тохируулан 120 орон тоо бүхий байхаар тооцоолон гаргасан байна. Одоогоор батлуулаагүй байна.	50%
Гүйцэтгэлийн хувь							69.8%

ТАЙЛАН БИЧСЭН: НХСЗЭҮТ ЭЭОД Л. ЭРДЭНЭБУЛАГ